



**МАРШАЛ Ю.ЦЭДЭНБАЛЫН НЭРЭМЖИТ ҮНДЭСНИЙ
ЛАБОРАТОРИ ЦОГЦОЛБОР 1-Р СУРГУУЛИЙН ТҮҮХТ 90
ЖИЛИЙН ОЙ ӨРГӨН ДЭЛГЭР БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.**

1926 оны намар Чандмань уулын аймгийн Баянчандмань уулын хошуунд Ятуун хэмээх Батын Равдангийн хичээл зүтгэл

дэмжлэгтэйгээр 29 сурагч /8-15 насны, эмэгтэй 5/-тай 2 гэрт “Хошууны танхим” нэртэйгээр анх байгуулагдсан Увс аймгийн ууган сургууль өдгөө Маршал



Ю.Цэдэнбалын нэрэмжит үндэсний лаборатори Цогцолбор 1-р сургууль болон өргөжин тэлж түүхт 90 жилийн ойгоо энэ өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлж байна.

Төрөлх сургуулийнхаа 90 жилийн ойд хүрэлцэн ирсэн хүндэт зочид төлөөлөгчид Маршал Ю.Цэдэнбалын хөшөөнд цэцэг өргөж, дурсгалын зураг татуулснаар баярын арга хэмжээ эхэллээ.

Баярын нээлтэнд УИХ-ын дэд дарга Ц. Нямдорж, Аймгийн засаг дарга Д.Батсайхан, ИТХ-ын дарга Э.Насанбат, ахмад багш нар болон одоо ажиллаж байгаа багш нар, тус сургуулийн үе үеийн төгсөгчид оролцлоо. Улмаар “Ойрад” ХЖТ-т баярын хурал, одон медаль, шагнал гардуулах ёслол, тус сургуулийн багш ажилчид, сурагчдын оролцсон хүндэтгэлийн тоглолт зохион байгуулагдлаа.

Аймгийн засаг дарга Д.Батсайхан хуралд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд мэндчилгээ дэвшүүлж уг хэлээд Төсвийн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, УИХын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, УИХ-ын гишүүн Н.Цэрэнбат, Монгол банкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан нарын мэндчилгээг уншиж танилцуулан сургуулийн захирал Н.Бүрэнд гардууллаа.

Тус сургуулиас Монгол төрийн нэрт зүтгэлтнүүд, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатрууд, гавъяатууд, эрдэмтэн, доктор, профессорууд, улс, аймаг, сумын

олимпиадын аваргууд, урлаг, спортын алартнууд төрөн гарснаас дурдвал:

БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, МУ-ын

маршал Ю.Цэдэнбал, АИХ-н тэгүүлэгчдийн дарга, МАХН-ын төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх болон 50 гаруй улс төрийн түшицэд, 11 хөдөлмөрийн баатар, 3 ардын цолтон, 100 гавъяат, 176 доктор энэ сургуулиас төрөн гарчээ. Эрдэм номын их уурхай болсон Цогцолбор 1-р сургууль 90 жилийнхээ ойгоор МУ-н Тэргүүний сургууль болсон нь үе үеийн багш, сурган хүмүүжүүлэгчид, удирдлагууд, нийт төгсөгчид, ажилтан албан хаагчид, одоо ажиллаж байгаа багш ажилчид, сурагчдын хичээнгүй зүтгэлийн үр дүн юм билээ.



**БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН
ЭРХТ ЭЛЧИН САЙД СИН ХАЙМИН УВС АЙМАГТ
АЙЛЧИЛЛАА.**

2016 оны 08-р сарын 14-17-ны өдрүүдэд манай аймагт БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Син Хаймин тэргүүтэй төлөөлөгчид айлчиллаа

Айлчлалын бүрэлдэхүүнд Элчин сайдын худалдааны зөвлөх Сунь Вэйрэн, Соёлын зөвлөх Ли Вэй, улс төрийн зөвлөх Ли Яньжунь, Элчин сайдын туслах Ван Цян, “Жен Юан” ХХК-ны ерөнхий менежер Ли Дэлянь, СНЕК Монгол Констракшин ХХК-ны ерөнхий менежер Гао Мин, техникийн ажилтан Фан Вэй нар хүрэлцэн ирсэн юм.

Элчин сайд болон бусад төлөөлөгчдийг аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат,

Засаг даргын орлогч

Ц.Батболд, ЗД-ын зөвлөх


Т.Нямсамбуу, АЗДТГ-ын дарга

С.Батжаргал, ХБХ-ийн дарга

Б.Бат-Ерөөлт, НХХ-ийн дарга

С.Амраа, ХБХ-ийн мэргэжилтэн

З.Ганболд нар хүлээн авч уулзаж боловсрол, соёл, эрүүл мэнд, бизнесийн болон салбар салбарт хамтарч ажиллах, 2 улсын хамтын ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, хамтын ажиллагааг шинэ түвшинд өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцлоо.



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД ХУРАЛДЛАА.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал 2016 оны 08-р сарын 19-нд хуралдаж дараах 5-н асуудлыг хэлэлцэн шийдвэрлээ. Үүнд:

ОНӨ-ийг барьцаалан зээл авах - Ю.Сайнжаргал /Дулааны 2-р станц, Дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ-ын захирал/

Монголын Нутгийн Удирдлагын Холбоотой хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулах тухай - Х.Дашзэвэг /Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч/

ОНӨ-ийн асуудал - Б.Баяртсайхан /Аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах мэргэжилтэн/

Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай - Ц.Батболд/Аймгийн Засаг даргын орлогч/

Шагналд тодорхойлох тухай - Д.Лхамхүү /Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн/

Хурлаар Дулааны 2-р станц, дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ-газарт өвөлжилтийн бэлтгэл ажил, дулааны эрчим хүчээр хэрэглэгчдийг аюулгүй, найдвартай, тасралтгүй хангах ажлыг гүйцэтгэхэд зориулж “Дулааны 2-р станц, дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ”-ын станцын барилгыг барьцаалан 150,0 сая /нэг зуун тавин сая / төгрөгийн зээлийг 5 сарын хугацаатай авахыг зөвшөөрлөө.

Мөн МНУХ-той цаашид хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн төслийг хэлэлцэн баталж, МНУХ-д хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Төрийн дээд одон медалиар шагнуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлөөс ирүүлсэн саналыг хэлэлцээд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт хүндэт” медалиар шагнуулахаар тус бүр нэг хүний материалыг дэмжин Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжлахаар боллоо.



“БАРУУН МОНГОЛЫН ШАШИН СОЁЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ 2-Р ХУРАЛ БОЛЛОО

Ойрад Монголд бурхан шашин дэлгэрсний 400 жилийн ойд зориулан “Баруун Монголын шашин соёл” эрдэм шинжилгээний 2-р хурлыг Увс аймгийн ИТХ, Дэчинравжайлин хийд, Ховд аймгийн Ганданпунцагчойлин хийд, Түүх соёл, хэл бичиг судлалын “Тод номын гэрэл” төв хамтран зохион байгуулж байна.

Хуралд ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн, доктор Б.Түвшинтөгс, МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор, дэд профессор На.Сүхбаатар, Ховд



аймгийн Ганданпунцагчойлин хийдийн хамба лам Б.Соёл-Эрдэнэ, Увс аймгийн Дэчинравжайлин хийдийн да лам Г.Чимэддорж, МУСГЗ, сэтгүүлч Б.Норов, Тувагийн Цэчинлин хийдийн хамба лам н.Баяр нарын зэрэг түүх, шашин судлалын ухааны эрдэмтэн, докторууд, ОХУ-н Тува улс, Увс аймаг болон Ховд аймгийн хийдийн лам нар оролцож Буддын шашин Ойрад Монголд дэлгэрсэн түүх, сүм хийдүүдийн хөгжил, уламжлалт дэг, жаяг, шаштир дууны утга санаа, онцлог, хувилгаадын үлдээсэн өв соёл, архивын баримтууд, лам нарын хөрөнгийг хураасан он цаг, хийдүүдийг дахин сэргээсэн үе, түүхэн лам нарын намтрыг тодруулах судалгаа, хийдийн шинэчлэл



сэдвүүдээр илтгэл тавьж санал бодлоо солилцоо. 08.05, 06-ны өдрүүдэд арга хэмжээ үргэлжлэх бөгөөд хуралд оролцогчид Төгсбуяантын хүрээний хуучин туурь, Улаангомьн хүрээний зуны буурийг үзэж сонирхох юм.

ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ ЗАЛУУЧУУД - ОЛОН УЛСЫН ЗАЛУУЧУУДЫН ӨДӨРТ

2000 оноос дэлхий дахинаа Олон улсын залуучуудын өдрийг жил бүрийн 8-р сарын 12-ны өдөр тэмдэглэн

УВС АЙМАГ

“Намайг Тулгын Амарзала гэдэг. 33 настай, дотрын эмч. 2016 онд Увс аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдсон.

ИТХ-д залуучуудын төлөөлөл харцангуй бага байсан, харин 2016 оны сонгуульд олон залуучууд төлөөлөгч болж орж ирсэн нь бахархуштай, гэхдээ бас хариуцлагатай байхыг шаардаж байна гэж үзэж байна. Орон нутгаа хөгжүүлэхэд залуучуудын оролцоо нөлөө их, бид ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралыг дээшлүүлэхийн тулд

- малын түүхий эд, ноос ноолуур, мах, сүү сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, зээлд нийлүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих,
- Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, брэнд болгон, зах зээлд нийлүүлэх, чанарыг сайжруулан экспортолох,
- сүм орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нүүдлийн соёл иргэншлийг таниулах сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- Эрүүл мэндийн салбарыг орчин үеийн техник технологиор бүрэн хангаж, эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад мэргэжил дээшлүүлснээр дотооддоо эмчилгээ, оношлогоог дэлхийн түвшинд хийдэг болох, ингэснээр гадагшаа урсгах мөнгөний урсгалыг зогсоох хэрэгтэй гэж бодож байна”.



өнгөрүүлж ирсэн билээ. Энэ жил Залуучуудын өдрийг 2030 он хүртэлх зам: Ядуурлыг бууруулж, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжихе “уриан дор тэмдэглэж байна.

2016 оны УИХ-ын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит удаагийн сонгуулиар сонгогдсон 35-хүртэлх насны төлөөлөгчидтэй Олон улсын залуучуудын өдрийг тохиолдуулан залуучуудын оролцоо, сонгуульт хугацаандаа хийхээр төлөвлөж буй ажил, тогтвортой хөгжлийн зорилтууд сэдвээр ярилцсан юм.

ТӨВ АЙМАГ



“Намайг Сүхбаатарын Байрмаа гэдэг. 31 настай. Банкны эдийн засагч мэргэжилтэй. 2008-2016 онд сумын ИТХ-д төлөөлөгч, Тэргүүлэгч, 2008-2012 онд сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байсан. 2016 онд Төв аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдсон.

Анх 23 настайдаа ИТХ-д нэр дэвшиж байхад хамгийн залуу нь байлаа. Тэр үед залуучууд маш ховор ИТХ-д байсан. Миний хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагад залуучуудыг олохор оруулах хүсэл эрмэлзэлтэй явдаг. Яагаад гэвэл залуучууд гэдэг маш их эрх хүчтэй, шинэ санал санаачлага гаргах тал дээр байнга өөрсдийгөө хөгжүүлж байдаг хүмүүс юм.

Орон нутгаа хөгжүүлэх талаар маш олон зүйлийг төлөвлөж бодож явдаг. Манай аймаг олон сумтай, дэд бүтэц сайн хөгжсөн ч гэсэн ажилгүйдэл, ядуурал аль ч суманд очсон байсаар л байдаг. Залуучууд энэ асуудалд өөрсдийн дуу хоолойг хүргэж байх нь маш чухал. Иймд өөрсдийгөө голлолгүй нутаг орноо хөгжүүлэх үйл хэрэгт зорилготой, зоригтой оролцох хэрэгтэй гэж боддог. Миний хувьд хамгийн түрүүнд хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх ажлыг хийнэ гэж бодож байгаа. Энэ асуудал энгийн боловч хугацаа шаардсан зүйл л дээ”.

БАЯНХОНГОР АЙМАГ



“Намайг Жамбалдоржийн Пүрэвсүрэн гэдэг. 31 настай. Өмнө нь Баян-Овоо сумын ИТХ-ын дарга, сумын засаг даргаар ажиллаж байгаад 2016 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон. Татварын эдийн засагч мэргэжилтэй.

Өмнөх ИТХ-уудтай харьцуулахад энэ удаагийн ИТХ-д залуучуудын төлөөлөл нэлээд их сонгогдсон. Залуу төлөөлөгчийн хувьд асуудал бүрт хариуцлагатай хандаж, хуулийн хүрээнд залуу хүний хүний сэтгэлгээ, эрх хүч, шийдэл зэргийг шийдвэрт оновчтой тусгаж байгаасай л гэж бодож байна”.

ОРХОН АЙМАГ

Орхон аймгийн ИТХ-ын төлөөлөгч Гомбосангийн Эрдэнэбат, 30 настай, инженер, эдийн засагч нягтлан бодогч.

“Өмнө нь ганц хоёр залуучууд ИТХ-д сонгогддог байсан ч яг шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, залуучуудынхаа санаа бодол, хүсэл сонирлыг илэрхийлж амжиллаж байсан үү гэвэл хангалттай биш санагддаг. Энэ удаад Орхон аймгийн ИТХ-ын 7 дэх удаагийн сонгуулийн дүнгээр залуучуудын төлөөлөл боломжийн хэмжээнд сонгогдсон. Гэхдээ залуучуудын дуу хоолой үгүйслэгдэж байсныг энд хэлмээр байна. Одоо залуучууд бид үгээр биш үйлдвэр харуулах цаг нь болсон гэж бодож байна.

Мэдээж иргэд сонгогчидноо итгэлгүй даана гэж сонгогдсон залуу хүний хувьд өөрөөсөө шалтгаалах бүхий л зүйлээ дайлдан ажиллах бодолтой явдаг. ИТХ-ын хуралдаанаас гарч байгаа шийдвэр иргэд, олон нийтийн санаа бодол, хүсэлтийг аль болох амар нэгэн байдлаар тусгахыг хичээж ажиллана. Бүгдээрэй хэлэлцвэл буруу шийдвэр гаргах нь бага боловч үү гэж боддог. Ажилгүй байгаа залуучуудыг мэргэжилтэй болгох цаашлаад ажил орлоготой болгох тал дээр түлхүү анхаарч ажиллана.



Тогтвортой хөгжлийн зорилтууд бол НҮБ-ээс баталсан Мянганы хөгжлийн зорилтыг илүү хөгжүүлж, шинэчилсэн үргэлжлэл нь гэж ойлгож байгаа. Дэлхийн 193 орны төлөөлөл харилцан хүлээн зөвшөөрч хүн төрөлхтний өмнө тулгамдаж байгаа ороонцоо харилцан хамааралтай асуудлуудыг системтэйгээр шийдвэрлэхээр Дэлхийг шинэчлэх нь: “Тогтвортой хөгжил-2030” тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлж баталсан. Энэ хөтөлбөрийг боловсруулахдаа дэлхийн 8 сая иргэний санал хүсэлтэд тулгуурласан төдийгүй Монгол Улсын хувьд 5000 иргэн саналаа өгсөн юм байна лээ. Энэ нь хэнийг ч орхиуулаагүй, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, эх дэлхийгээ хамгаалж, хүн төрөлхтнийг тайван амгалан, баян чинээлэг, эрх тэгш амьдрах боломжоор хангах даан дэлхийн уриалга юм шүү дээ”.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас : 70453627

Факс : 70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал